



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	“Өндөрхаан итгэл аудит” ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	5
3.4 Материаллаг байдал	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	8
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
4.1 Залруулсан алдаа	9
4.2 Төлбөрийн акт	9
4.3 Албан шаардлага	9
4.4 Зөвлөмж	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

додд. 03.23 № 300

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хүүхдийн нэгдүгээр Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Нэгдүгээр Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хэрлэн сумын 1 дүтээр цэгцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	124,755,018.96	123,428,474.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	124,755,018.96	123,428,474.60
351	Түүхий эд материал	110,065,290.96	108,726,907.60
35110	Тусгай зориулалттай материал	109,472,190.96	108,327,607.60
35130	Эм боох материал	593,100.00	399,300.00
354	Хангамжийн материал	14,689,728.00	14,701,567.00
35410	Бичиг хэргийн материал	4,817,100.00	6,093,100.00
35420	Аж ахуйн материал	5,433,240.00	3,217,750.00
35440	Тулш, шатах тослох материал	150,000.00	460,000.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	4,289,388.00	4,930,717.00
35470	Бусад хангамжийн материал	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	433,230,886.21	406,489,112.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	433,230,886.21	406,489,112.28
392	Биет хөрөнгө	297,505,886.21	270,764,112.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	190,996,712.24	190,996,712.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,770,309.46)	(42,223,851.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	79,370,033.47	80,870,033.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,578,625.21)	(44,798,728.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	122,834,587.15	135,084,587.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,346,511.98)	(49,164,640.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	135,725,000.00	135,725,000.00
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	135,725,000.00	135,725,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	557,985,905.17	529,917,586.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	557,985,905.17	529,917,586.88
51	Засгийн газрын хувь оролцоо	557,985,905.17	529,917,586.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	283,287,812.72	283,287,812.72
51101	Өмч - төрийн	283,287,812.72	283,287,812.72
512	Хуримтлагдсан үр дүн	248,996,882.15	220,928,563.86
51210	Өмнөх үеийн үр дүн	248,996,882.15	248,996,882.15
51220	Тайланг үеийн үр дүн	-	(28,068,318.29)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,701,210.30	25,701,210.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	557,985,905.17	529,917,586.88

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгсгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	783,792,318.65	606,676,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,657,518.65	64,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	63,657,518.65	64,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,657,518.65	64,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63,657,518.65	64,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	720,134,800.00	606,611,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	655,687,600.00	558,711,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	655,687,600.00	558,711,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,000.00	756,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	721,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,272,200.00	47,143,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,272,200.00	47,143,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	667,519,061.79	634,744,818.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,519,061.79	634,744,818.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,992,056.17	552,403,735.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,152,974.56	379,913,316.69
210101	Үндсэн цалин	259,926,152.20	282,705,621.15
210102	Нэмэгдэл	78,348,437.36	63,852,230.70
210104	Урамшуулал	26,878,385.00	33,355,464.84
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,789,703.23	50,776,873.06
210201	Тэтгэврийн даатгал	32,226,670.20	35,463,193.76
210202	Тэтгэмжийн даатгал	3,643,249.06	3,899,933.67
210203	ҮОМШО-ний даатгал	2,905,555.31	3,047,275.83
210204	Ажиг үйлдлийн даатгал	727,770.55	751,412.49
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,458.11	7,615,057.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,535,639.59	41,375,932.00
210301	Гэрэл, цахилгаан	3,350,108.00	3,234,652.00
210302	Түлэн, халаалт	48,801,251.59	33,828,320.00
210303	Цэвэр, бохир ус	5,384,280.00	4,312,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,146,355.00	17,224,372.36
210401	Бичиг хэрэг	739,400.00	2,211,900.00
210402	Тээвэр, шатахуун	570,000.00	190,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	762,335.00	1,181,049.00
210404	Ном, хэвлэл	-	6,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	738,150.00	607,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,336,470.00	13,027,723.36
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал актисны зардал	-	-
2105	Нормативт зардал	31,751,392.50	20,127,067.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	367,900.00	1,022,500.00
210502	Хоол, хүнс	31,383,492.50	19,104,567.00
210503	Нормын хувцас, зоолон одтөл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,434,500.00	757,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	1,434,500.00	757,400.00
2107	Томилот, зочны зардал	-	159,000.00
210702	Дотоод албан томилот	-	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зөрлөг тогтоох	324,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,857,491.29	41,061,773.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,121,300.00	570,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорөгдол	30,736,191.29	40,491,773.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,527,005.62	82,341,083.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,260,610.41	5,294,668.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,260,610.41	5,294,668.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,766,395.21	76,546,415.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,766,395.21	76,546,415.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	116,273,256.86	(28,068,318.29)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	116,273,256.86	(28,068,318.29)

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

2021 оны 12 дугаар сарын 31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	132,723,625.29	441,712,648.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	132,723,625.29	441,712,648.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	116,273,256.86	116,273,256.86
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	248,996,882.15	557,985,905.17
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	248,996,882.15	557,985,905.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	248,996,882.15	557,985,905.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валкотын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(28,068,318.29)	(28,068,318.29)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	283,287,812.72	25,701,210.30	220,928,563.86	529,917,586.88

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төрөгөөр/

2021 оны 12 дугаар сарын 31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	720,134,800.00	606,611,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	720,134,800.00	606,611,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	655,687,600.00	558,711,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	655,687,600.00	558,711,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,000.00	756,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	721,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,272,200.00	47,143,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,272,200.00	47,143,500.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	667,621,881.00	592,861,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667,621,881.00	592,861,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,094,875.38	510,720,616.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,866,410.56	379,913,316.69
210101	Үндсэн цалин	259,896,103.82	282,705,621.15
210102	Нэмэгдэл	77,091,921.74	63,852,228.54
210104	Урамшуулал	26,878,385.00	33,355,467.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,789,703.23	50,776,873.06
210201	Тэтгэврийн даатгал	32,226,670.22	35,463,193.76
210202	Тэтгэмжийн даатгал	3,643,249.15	3,899,933.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,905,554.92	3,044,033.83
210204	Ажилгүйдлийн даатгал	727,770.68	754,654.49
210205	Эрүүл мэндийн даатгал	7,286,458.26	7,615,057.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,535,639.59	41,375,932.00
210301	Гэрэл, цахилгаан	3,350,108.00	3,234,652.00
210302	Түлш, халаалт	48,801,251.59	33,828,320.00
210303	Цэвэр, бохир ус	5,384,280.00	4,312,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,535,877.00	6,832,299.00
210401	Бичиг хэрэг	3,659,400.00	723,950.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	762,335.00	1,181,049.00
210404	Нөм, хэвлэл	111,600.00	136,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	975,000.00	470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,527,542.00	3,821,300.00
2105	Нормативт зардал	33,042,495.00	26,040,796.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	852,000.00	1,344,900.00
210502	Хоол, хүнс	24,575,495.00	19,745,896.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	7,615,000.00	4,950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,355,950.00	472,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,880,000.00	-
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	2,475,950.00	472,900.00
2107	Томилголт, зочны зардал	-	159,000.00
210702	Дотоод албан томилголт	-	159,000.00
2108	Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,800.00	4,141,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,644,800.00	3,841,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,527,005.62	82,141,083.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	300,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,260,610.41	5,294,668.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,260,610.41	5,294,668.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,766,395.21	76,546,415.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,766,395.21	76,546,415.25
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,512,919.00	13,750,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,512,919.00	13,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,512,919.00	13,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,512,919.00	13,750,000.00
223001	Бусад хөрөнгө	52,512,919.00	13,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(52,512,919.00)	(13,750,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,855,000.00	524,013,916.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,855,000.00	524,013,916.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,555,000.00	523,713,916.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,411,900.00	379,913,316.69
210101	Үндсэн цалин	281,901,900.00	282,705,621.15
210102	Нэмэгдэл	83,154,500.00	63,852,228.54
210104	Урамшуулал	33,355,500.00	33,355,467.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,922,400.00	50,776,873.06
210201	Тэтгэврийн даатгал	41,143,900.00	35,463,193.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,444,700.00	3,899,933.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,555,700.00	3,044,033.83
210204	Ажилгүйдлийн даатгал	888,900.00	754,654.49
210205	Эрүүл мэндийн даатгал	8,889,200.00	7,615,057.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,658,300.00	41,375,932.00
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	3,234,652.00
210302	Түлш, халаалт	35,158,300.00	33,828,320.00
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	4,312,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,386,500.00	6,297,299.00
210401	Бичиг хэрэг	724,200.00	723,950.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,181,600.00	1,181,049.00
210404	Ном, хэвлэл	137,100.00	136,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	540,000.00	470,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,303,600.00	3,286,300.00
2105	Нормативт зардал	75,495,600.00	25,819,096.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,126,000.00	1,123,200.00
210502	Хоол, хүнс	69,410,000.00	19,745,896.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдгэл	4,959,600.00	4,950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,735,200.00	12,722,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	12,250,000.00	12,250,000.00
210604	Урсгал засвар	485,200.00	472,900.00
2107	Томилголт, зочны зардал	229,100.00	159,000.00
210702	Дотоод албан томилголт	229,100.00	159,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	1,008,000.00	1,008,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,708,000.00	5,641,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	332,400.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,375,600.00	5,341,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	605,855,000.00	524,013,916.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	558,711,500.00	482,165,084.75
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	558,711,500.00	482,165,084.75
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,143,500.00	41,848,832.00
132001	Орон нутгийн төсвөөс	47,143,500.00	41,848,832.00

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

2021 оны 12 дугаар сарын 31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	756,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	756,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	756,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	535,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	535,000.00
2105	Нормативт зардал	-	221,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	221,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	756,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	756,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарьсан хөрөнгө	-	721,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор П.Мөнгөнтуул, аудиторын туслах Ж.Батсайхан нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 557,519.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,575.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,460.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,068.3 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага			-
Урьдчилгаа			-
Бараа материал	124,755.00	123,428.50	(1,326.50)
Үндсэн хөрөнгө	433,230.90	406,489.10	(26,741.80)
Нийт хөрөнгө	557,985.90	529,917.60	(28,068.30)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	557,985.90	529,917.60	(28,068.30)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	283,287.80	283,287.80	-
Хуримтлагдсан үр дүн	248,996.90	248,996.90	-
Тайлант үеийн үр дүн		(28,068.30)	(28,068.30)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,701.20	25,701.20	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	557,985.90	529,917.60	(28,068.30)

Бараа материалын дансны үлдэгдэл нь 123,428.5 мянган төгрөг болж 1,326.5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, бусад аж ахуйн материалын өөрчлөлттэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 406,489.1 мянган төгрөг болж 26,741.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны 34,841.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 220,928.6 мянган төгрөг болж, 28,068.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлт байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 177,115.8 мянган төгрөгөөр буюу 22.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 96,976.1 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 63,592.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 32,774.3 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл түлш халаалтын зардал 14,973.0 мянган төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 871,107.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 265,252.7 мянган төгрөгөөр бууруулан 605,855.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: түлш халаалтын зардлыг 24,514.5 мянга, цалингийн зардлыг 59,479.9 мянга, хоол хүнсний зардлыг 88,123.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг 2,705.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 605,855.0 мянган төгрөг баталсанаас 558,711.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,143.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 558,711.5 мянга, орон нутгийн төсвөөс 47,143.5 мянга, нийт 605,855.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 524,013.9 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 76,546.4 мянга, орон нутгийн төсөвт 5,294.7 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524,013.9 мянган төгрөг буюу 86.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 18,498.6 мянга, хоол хүнсний зардлыг 49,664.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 721.7 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35.0 мянга, нийт 756.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих 144 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөнөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,537.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 467.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 4,070.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 467.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Тайлант онд нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 467.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь ЗГ-ын 450 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

4.4.1 Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 4,070.0 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хэрлэн сумын 1 дүгээр Цэцэрлэг	2	4,537.3			1	467.3			1	4,070.0
	Дүн	2	4,537.3			1	467.3			1	4,070.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 30/239/06/0

Чингис хот

ХТА 2022/147/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг 467.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2,475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосон"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" 4.2.3.6" эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Норматив хэтрүүлж зарцуулсан 467.3 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн эрхлэгч П.Болортунгалаг, нягтлан бодогч Д.Цэгмэд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



023059683